



**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 5-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙГАЛИЙН ХОВОР УРГАМАЛ ТАРИАЛАХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2787172/*

## Агуулга

1	Төслийн товч танилцуулга .....	1
1.1	Төслийн зорилго .....	1
1.2	Төслийн байршил .....	1
1.3	Төсөл хэрэгжүүлэх үе шат .....	1
1.4	Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ .....	2
2	Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	2
3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	4
4	Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт .....	6
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	7
6	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .....	11
7	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	18
8	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	18
9	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	19
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	21
11	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	36
12	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	39
	Тайлангийн хавсралтууд .....	41

# 1 Төслийн товч танилцуулга

## 1.1 Төслийн зорилго

Монгол улсдаа Анагаах ухаан, Экологи эдийн засгийн өндөр ач холбогдолтой эмийн түүхий эд, хоол хүнсний туслах найрлага болох Урал чихэр өвсийг “*Glycyrrhiza uralensis*” тариалж дотоодын хэрэгцээгээ хангаад зогсохгүй гадаад орнууд руу экспортлох зорилготой.

## 1.2 Төслийн байршил

Төслийн нэр: Байгалийн ховор ургамал тарих


Төсөл хэрэгжүүлэх байгууллага: “Аялуун фарм” ХХК

Регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар: РД:2787172, УБГ:9011047023

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Дизайнер төв, Ард Аюушийн гудамж, Баянгол дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс

Хариуцсан ажилтны нэр, утас: Ц.Чингүнбат, 70003839

Төслийн байршил: Төслийн талбай нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5-р багийн нутаг дэвсгэрт, аймгийн төвөөс 5-6 км зайд байрлана.



## 1.3 Төсөл хэрэгжүүлэх үе шат

Төслийн талбайд 2019 оны 6-р сард Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн

ба 2020 оноос эхлэн Байгалийн ургамлын тухай хуулийг мөрдөж ургамлын мэргэжлийн байгууллагад бүртгүүлэн шаардлагатай хашаа, худаг, тоног төхөөрөмж, түүхий эд материал, барилга байгууламж, ажиллах боловсон хүчин зэргийг бэлтгэсэний дараа туршилтын эмийн ургамлыг тариалж эхэлнэ гэж төлөвлөж байсан боловч дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахал гарсны улмаас төлөвлөгөөт ажлууд хойшлогдож 2022 онд эзэмшлийн талбайг хашаалах болон худаг гаргах, зөөврийн сууц, гэр, хүлэмж байршуулах ажлууд хийгдсэн бөгөөд 2023 оноос эхлэн туршилтын тариалалтыг эхлүүлсэн ба тасалгаа болон зуны хүлэмжид үрслүүлсэн 14,102 ш үрсэлгээг ил талбайд (0.5 га) шилжүүлэн суулгасан. 2024 онд мөн энэ зарчмын дагуу 27,999 ш үрсэлгээг ил талбайд (1.0 га) шилжүүлэн суулгасан. Цаашид үрээр шууд тариалалт хийх боломжтой эсэхийг тогтоох үүднээс зуны хүлэмжний зүүн талд 0.05 га үрээр тарих туршилтыг эхлүүлсэн.

#### **1.4 Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ**

Дэлхийн ихэнх улсын чихэр өвсний үндэс байгалиас ухагдаж тухайн ургамлын нөөц хомсдож байна. Жишээ нь 1990 оны үед Хятад улс 8000-10000 тонн чихэр өвсийг үндэс болон шахмал байдлаар экспортлож байсан боловч, 2006 онд 3500 тонн болтлоо багасаж импорт нь 4000 тонн болж ихэссэн. Хятад улс нь эртнээс чихэр өвсний үндэс болон түүнээс гаралтай түүхий эдийг экспортлож ирсэн боловч одоогийн байдлаар өөрөө цэвэр импортлогч орон болсон. Энэ нь тус ургамлын хэрэгцээ ихэссэнтэй холбоотой биш Хятадын нөөц багассантай холбоотой юм.

Дэлхийн 4-ний нэгийг эзэлдэг Европд чихэр өвсний үндэсний хэрэгцээ ихсэж байна. 2017-2025 оны хооронд зах зээлийн өсөлт нь жилд 4%-иар өснө гэсэн таамаглал бий. Хүнсний нэмэлт бодис болон эмийн түүхий эд болох чихэр өвсний хэрэгцээ ихсэхийн зэрэгцээ байгалийн нөөц хомсдож эхлэж байна. Иймд чихэр өвсийг эх орондоо тариалж бага ч болтугай байгалийн нөөц баялагийг урьдчилан хамгаалж, байгаль дэлхийд хувь нэмрээ оруулахаар зорьж байна.

## **2 Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт**

**Газарзүйн мужлал:** Төсөл хэрэгжих талбай нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5-р багийн нутаг дэвсгэрт, аймгийн төвөөс 5-6 км зайд байрлана. Хэрлэн сум нь Хэнтийн нуруунаас эх авсан Хэрлэн голын ай сав бүхий тал хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1031 м өндөрт оршдог. Физик газарзүйн мужлалын хувьд Монголын дорнод талын их мужийн, Халхын дундад ба Дарьгангын талархаг дэд мужийн, Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт, Байгалийн бүс, бүслүүрээрээ хээрийн бүсэд хамаарагдана.

**Уур амьсгал:** Хэнтий аймгийн нийт нутаг дэвсгэр нь хотгор гүдгэрийн ялгаа ихтэй учраас өвөл зуны температурын хэлбэлзэл их байна. Хамгийн дулаан сар 7 сар байх бөгөөд сарын дундаж температур +18.8°C байна. Үнэмлэхүй их температур нь 32.6-36.9°C хүрч халах бөгөөд зарим жил 38.1-39.7°C хүрч халдаг байна. Хөрсний гадарга дээр зундаа 64-69°C хүртэл халж, өвөлдөө -40-45°C хүртэл хүйтэрдэг. Хаврын эцсийн цочир хүйтрэл 5-р сарын сүүлчээр, намрын эхний цочир хүйтрэл 9-р сарын 10-аар тохиолдох учир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 110 хоног байна. 0°C-ээс дээш температуртай хоногийн тоо жилдээ 193, 10°C-ээс дээш температуртай хоногийн тоо жилдээ 126 хоног буюу ургамал ургалтын хугацааны дулааны нөөц нэн хангалттай байна. Чингис хотод жилдээ 265 мм орчим хур тунадас орох бөгөөд хур тунадасны 92 орчим хувь нь жилийн дулаан улирал буюу 4-9-р саруудад орно. Жилдээ дунджаар 22 өдөр аянга цахилгаантай бороо ордог ба хамгийн олондоо 40 өдөр хүрч байжээ. Жилийн дундаж салхины хурд 3.6 м/с, хаврын саруудын салхины дундаж хурд 3.8-4.7 м/с байдаг.

**Гадаргын ус:** Төслийн талбайн нь ус зүйн мужлалаар Номхон далайн ай сав, Сав газраар Хэрлэн голын сав газарт орно. Төслийн талбайгаас урд зүгт 2.3 км зайд Хэрлэн гол байна.

**Газрын доорх ус:** Газрын доорх усны их нөөцтэй талбай нь Хэрлэн голын татам дагуу, Онон, Балж, Хурх, Барх голуудын өргөшсөн татам болон зарим жижгэвтэр голуудын хөндийд орших нуур, аллювийн хурдас тархсан өргөшсөн хэсгүүдийг эзлэн байрлана. Эдгээр талбайд зонхилон тархсан аллювийн хурдасны зузаан нь их ус дамжуулах чадвар нь 40-3500 м<sup>2</sup>/хоног хүртэл хэмжээнд хэлбэлздэг, дундаж хэмжээ нь 300 орчим м<sup>2</sup>/хоног байна. Газрын доорх усны урсац их /120-150мм/жил/ бөгөөд тухайн орчимд гаргасан 45 худгийн материалыг үндэслэн хийсэн тооцоогоор газрын доорх усны модуль нь 0.41-0.96 л/с\*км<sup>2</sup> байна.

**Хөрс:** Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн өргөргийн бүсшилтэй нутгийн хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн Өндөрхаан-Түмэнцогтын тойрогт хамрагдаж байна. Судалгааны талбайд нэлэнхүйдээ хүрэн шороон хэв шинжийн хөрсний дэд хэв шинж болох жинхэнэ хүрэн хөрс тархсан байна.

**Ургамал:** Монгол орны нутаг дэвсгэрийн 25.85%-ийг эзлэх хуурай хээрийн бүсэд хамаарах ба ургамал газар зүйн мужлалаар манай улсын нийт нутаг дэвсгэрийн 11.54%-ийг эзэлж, одоогоор 500-аас дээш зүйл ургамал агуулсан Дундад Халхын хээрийн тойрогт хамаарч байна. Төслийн талбайн ургамалшилт олон арван жил суурьшил, бэлчээр, тариаланд маш их талхлагдсан, байгалийн унаган төрхөө олоогүй буюу атаршсан шинжээрээ байна.

**Амьтан:** Амьтны аймгийн газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их муж, Хэнтийн дэд муж, Хэнтийн гол нурууны тойрогт хамрагдана. Энэхүү бүс нутаг нь амьтны аймгийн бүрдлийн хувьд хээрийн амьтад зонхилон тархсан байдаг. Төслийн талбай түүний ойр орчмын гадаргын төрх байдал, ургамлан нөмрөгийн байдлаас үзэхэд үхэр, адуу олноороо байнга бэлчдэг нутаг тул ургамлан нөмрөг доройтсон, хөл газрын ургамал ихтэй болсон тул шавжийн аймгийн бүрэлдүүнээр тийм ч баялаг биш байна. Энд шулуун далавчтан (царцаа, голио), цох (Coleoptera), эрвээхий (Lepidoptera), хальсан далавчтан Hymenoptera (зөгий, шоргоолж), ялаа (Diptera) зэрэг олон багийн олон зүйл шавж амьдарч байгалийн бодисын эргэлт, оршин тогтноход чухал үүрэг гүйцэтгэнэ. 4 багийн 18 зүйл шувуу тохиолдохоос боршувуутаны багийн шувуу олон (11 зүйл) зүйл байдаг ба суурин амьдарч тал хувь нь хүнд ойромсог шувуунд тооцогддог. Тус нутагт тархалт нь тэмдэглэгдсэн 3 багийн 11 зүйл хөхтөн амьтан амьдрах боломжтой.

**Газар ашиглалт:** Хэрлэн сумын газар нутаг нийт 380,878.0 га талбайтай үүнээс Хөдөө аж ахуйн газар 363,569.9 га буюу 95.46%, Хот, тосгон бусад суурины газар 14,604.4 га буюу 3.83%, Зам, шугам сүлжээний газар 2,378.2 га буюу 0.62 %, Усны сан бүхий газар 321 га буюу 0.08%, Улсын тусгай хэрэгцээний газар 4.5 га 0.001%-г тус тус эзэлж байна. ХАА-н газраас хамгийн их хувийг бэлчээрийн зориулалттай газар эзлэх ба 4.28%-ийг тариалан, 2.66%-ийг хадлан, 2.41%-ийг атаршсан талбай эзэлж байна.

**Нийгэм, эдийн засгийн байдал:** Хэрлэн сум нь засаг захиргааны анхан шатны нэгж болсон Хэрлэн, Булаг, Баянмөнх, Сариг, Өндөрхаан, Цогт-Өндөр, Номгон, Ишгэн толгой гэсэн 8 багтай. 2018 оны жилийн эцсийн байдлаар 7552 өрхийн 23671 хүн ам амьдарч байна. Хүн амын хүйсийн харьцааг авч үзвэл эмэгтэйчүүд давамгайлах хандлагатай байна. 2014 оноос хойш нийт өрхийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд үүнийгээ дагаад сумын төвийн суурьшил нэмэгдэж байна.

2014-2018 оныг харьцуулан үзэхэд ажилгүй иргэдийн тоо буурсан хандлагатай байгаа хэдий ч ажил эрхлэх боломжит насны иргэдийн /25-29 нас/ тоо өссөн байна. 2018 онд Хэрлэн суманд 487.55 мянган мал тоологдсон ба үүнээс тэмээ 0.42, адуу 28.89, үхэр 33.29, хонь 245.94, ямаа 179.03 мянган толгой тус тус тоологджээ. Сүргийн бүтцийн хувьд авч үзвэл ямаа, хонин сүрэг

дийлэнх хувийг эзлэнэ. Сүүлийн 5 жилийн хугацаанд тариалан эрхлэлт буурах хандлага ажиглагдсан боловч ургац хураалтын хэмжээ 2018 онд хамгийн өндөр байна.

Хэрлэн сумын хэмжээнд бүртгэлтэй 700 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч бий. Ихэвчлэн нийтийн ахуй үйлчилгээ, хүнсний үйлдвэрлэл, гар урлал, сүү сүүн бүтээгдэхүүн, цагаан идээний үйлдвэрлэлээр данган үйл ажиллагаа явуулж байна.

### 3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Байгаль орчны бүрдэл тус бүрээр төслийн үйл ажиллагаанаас учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэхэд **30%** буюу **нөлөөлөлгүй**, **50%** буюу **бага** нөлөөлөлтэй, **20%** буюу **дунд** нөлөөлөлтэй гэж үнэлэгдлээ. Төслийн үйл ажиллагаанаас их болон хүчтэй нөлөөлөл үүсэхгүй ба ерөнхийд нь дүгнэвэл байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл “**Бага**” гэж үнэлэгдэхээр байна.

Төслийн үйл ажиллагаанаас хөрс, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл бусад бүрдэл хэсгүүдээс их байгаа боловч энэ нь тодорхой цэгт, бага хэмжээний нөлөөлөл үүсгэнэ.

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар					Тайлбар
	Нөлөөлөлгүй	Бага	Дунд	Их	Хүчтэй	
<b>Агаарын чанар</b>						
Хүйтний улиралд барилга байгууламжийг түлж халаахад агаарт бохирдуулагч бодис /SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO/ ялгарах	+					Дулаан хангамжаа цахилгаан халаалтаар шийдэх учир агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй.
Шороон замаар тээвэрлэлт хийх, газар хагалах үед богино хугацаанд тухайн орчны агаарт тоосжилт үүсэх		+				Төслийн эхний үе шатанд сумын төвөөс төслийн талбай хүртэлх шороон замаар тээвэрлэлт хийх ба энэ нь тодорхой цэгт, богино хугацаанд тоосжилт үүсгэнэ. Цаашид хатуу хучилттай зам тавих учир энэхүү нөлөөлөл арилна.
<b>Гадаргын болон газрын доорх ус</b>						
Удаан хугацааны турш худгаас ус авч ашиглахад газрын доорх усны түвшин буурч, нөөц багасах		+				Ундны усыг цэвэршүүлсэн баллонтой усаар, ахуйн хэрэглээний усыг төслийн талбайд гаргасан худгаас хангахаар төлөвлөсөн. Харин усалгаанд хэрэглэх усыг Хэрлэн голоос зөөвөрлөн ирж ашиглах боломжтой.
<b>Газрын гадарга, хөрс</b>						
Барилга байгууламж барих, зам талбай тавих, тариалангийн талбай хагалах үед хөрс доройтох, дарагдах, эвдрэлд орох			+			Төслийн G4 талбайд агуулах, оффисын байр зэргийг 225 м <sup>2</sup> талбайд барих үед газрын гадарга эвдрэлд орно. Газар хагалах, ургац хураах үед хөрс бүтцээ алдана.

Гадаргын төрх байдал өөрчлөгдөх		+				Гадаргын төрх байдал төдийлөн өөрчлөлтөнд орохгүй, өнгөн хэсэг нь эвдрэлд орно.
Шатах тослох материал асгарч алдагдсанаас хөрс бохирдох		+				Үйл ажиллагаанд ашиглах техник хэрэгслийн эвдрэл гэмтлээс үүдэн гэнэтийн асгаралт үүссэнээр хөрс бохирдож болзошгүй.
Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг ил задгай асгаснаар хөрс бохирдох	+					Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг танканд цуглуулж, тухай бүрт соруулан аймгийн төвийн цэвэрлэх байгууламжид нийлүүлэх учир газрын доорх ус, хөрсний бохирдол үүсгэхгүй.
Пестицид, гербицид хэрэглэснээр хөрсний бохирдол үүсгэх	+					Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор химийн найрлага бүхий бодис, бордоо ашиглахгүй органик бордоо хэрэглэх тул хөрсийг бохирдуулахгүй.
Ургамал						
Ургамлан бүрхэвч гэмтэх, дарагдах, талхлагдах, устгах			+			Барилга байгууламж барих, газар хагалах үед ургамлан бүрхэвч устаж үгүй болно.
Амьтан						
Мэрэгч, шавжийн амьдрах орчин хумигдах		+				Төслийн талбайд үлийн цагаан оготно элбэг тархсан байгаа бөгөөд тариалалт эхлэх үед эдгээр хортон мэрэгчдийг мэргэжлийн байгууллагаар устгал хийлгэж тоо толгойг нь багасгахаар төлөвлөсөн байна.
Нийлбэр оноо	3	5	2			

#### 4 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтын дагуу хийж гүйцэтгэв.

“Аялуун фарм” ХХК нь 2024 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд нийт 9.9 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн ба 50 сая төгрөгийг зарцуулсан байна. Гүйцэтгэлийг доорх хүснэгтэд үзүүлэв.

№	Хийгдэх ажлын чиглэл	Төлөвлөсөн зардал, ₮	Зарцуулсан зарал, ₮
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,072,000	675,574.4
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,000,000	20,592,500
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,600,000	2,600,000
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	612,000	612,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,755,400	3,239,000
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	600,000	21,000,000
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	1,350,000	1,350,000
Нийт		9,989,400	50,069,074.4



## 5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелүүлсэн байдал	Биелэлтийн хувь
5.1	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулан заасан хэмжээнд ашиглах	2024 оны 05-р сарын 27-ны өдрийн 1/88 дугаартай албан бичгээр Хэрлэн голын сав газрын захиргаагаар “Ус ашиглах дүгнэлт”-ийг гаргуулсан. Дүгнэлтэд 9,314.12 м <sup>3</sup> /жил ус ашиглахаар тусгагдсан ба тайлант онд нийт 1,334 м <sup>3</sup> ус ашигласан.	100%
5.2	Ус ашиглах гэрээ байгуулах, сар бүр акт үйлдэн усны нөөц ашигласны төлбөр төлөх	Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай 2024 оны 05-р сарын 30-ны өдөр БОАЖГ2024/02 дугаартай Ус ашиглуулах гэрээг байгуулсан. Хэрлэн сумын байгаль хамгаалагчаар усны тоолуурын актыг баталгаажуулан, усны нөөц ашигласны төлбөрт 123,574.40 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.	100%
5.3	Худгийн байрны ойр орчмын хог хаягдлыг цэвэрхэн байлгах	Уст цэгийн эрүүл ахуйн дэглэмийг мөрдүүлэх үүднээс худгийн ойр орчмын хог хаягдлыг тогтмол цэвэрлэж, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг нэгдсэн хогийн цэг рүү тээвэрлэн зайлуулсан.	100%
5.4	Жорлонгийн орчимд ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис цацах	Эко жорлонгийн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, хорхой шавж, нян үржихээс сэргийлсэн.	100%
5.5	Бохир соруулах зориулалтын машинаар соруулж аймгийн цэвэрлэх байгууламжид нийлүүлэх	2024.01.03-ны өдөр “Хэнтий-Ус” ХХК-тай бохир соруулах үйлчилгээний гэрээ байгуулсан ба тухайн онд эко жорлонгийн бохир усны хэмжээ соруулах хэмжээнд хүрээгүй.	100%

### 5.1 Ус ашиглуулах дүгнэлт гаргуулан заасан хэмжээнд ашиглах

2024 оны 05-р сарын 27-ны өдрийн 1/88 дугаартай албан бичгээр Хэрлэн голын сав газрын захиргаагаар “Ус ашиглах дүгнэлт”-ийг гаргуулсан (Хавсралт 1).

Ус ашиглуулах дүгнэлтэд нийт 9,314.12 м<sup>3</sup>/жил ус ашиглахаар туссан. Үүнд:

- Унд ахуйд 91.12 м<sup>3</sup>/жил
- Чихэр өвсний туршилтын тариалалтад 4,025 м<sup>3</sup>/жил
- Таримал ургамлын усалгаанд 4,100 м<sup>3</sup>/жил
- Ногоон байгууламжийн усалгаанд 1,098 м<sup>3</sup>/жил

2024 онд нийт 1,334 м<sup>3</sup> ус ашигласан ба дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрээгүй болно.

### 5.2 Ус ашиглах гэрээ байгуулах, сар бүр акт үйлдэн усны нөөц ашигласны төлбөр төлөх

Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай 2024 оны 05-р сарын 30-ны өдөр БОАЖГ2024/02 дугаартай Ус ашиглуулах гэрээг байгуулсан (Хавсралт 2). Худаг тус бүрийн тоолуурын заалтыг сар бүр дэвтэрт бүртгэж, баталгаажуулсан.

2024 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1,334 м<sup>3</sup> ус ашигласан. Үүнээс:

- Унд ахуйд 90.0 м<sup>3</sup>/жил
- Чихэр өвсний туршилтын тариалалтад 948 м<sup>3</sup>/жил
- Таримал ургамлын усалгаанд 0 м<sup>3</sup>/жил
- Ногоон байгууламжийн усалгаанд 296 м<sup>3</sup>/жил

Хэрлэн сумын байгаль хамгаалагчаар Усны тоолуурын актыг баталгаажуулж, усны нөөц ашигласны төлбөрт 123,574.4 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн (Хавсралт 11).

Хүснэгт 1. Худгийн тоолуурын заалт, м<sup>3</sup>

Худгийн дугаар	Тоолууны дугаар	Тоолуурын заалт №1	Фото зураг	
Худаг №1	202301564	00099		
	202301561	00120		
Худаг №2	202301477	00652		
	202301429	00749		

Зураг 1. Усны тоолуурын баталгаажуулалт

**УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

2024.11.01 Хэрлэн сум

Худгийн дугаар	Тоолууны дугаар	Тоолуурын заалт		Унд ахуйд	Чихэр өвсний туршилтын тарналагтад	Таримал ургамлын усалгаанд	Ногоон байгууламжийн усалгаанд	Нийт м <sup>2</sup>
		Өмнөх заалт	Дараах заалт					
1	202301564	00036	00069	-	-	-	63	63
	202301561	00043	00120	-	-	-	77	77
2	202301477	00101	00652	40	441	-	70	551
	202301429	00106	00749	50	507	-	86	643
Худгийн ус нийт				90	948	-	295	1334

**БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН:**  
ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН  
БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙН  
ОГНОО... 2024.11.01.....

**АКТ ҮЙДСЭН:**  
УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ  
"АЯЛУУН САРМ" ХХК  
ОГНОО... 2024.11.01.....

М.НОМИНЦЭЦЭГ  
 /Д.БУЛГАНБАЯР/

### 5.3 Худгийн байрны ойр орчмын хог хаягдлыг цэвэрхэн байлгах

Худгийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх үүднээс ойр орчимд үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж талбайн эмх цэгцийг ханган ажилласан.

Зураг 2. Худгийн байр орчмын цэвэрлэгээ хийж буй байдал





Хойд талбайд байрлах Худаг №1



Урд талбайд байрлах Худаг №2

#### 5.4 Жорлонгийн орчимд ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис цацах

Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль болон Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын албан даалгаварын хүрээнд аливаа үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллага нь хөрс бохирдуулагч стандартын бус нүхэн жорлон гаргах, ашиглахыг хориглосон байдаг. Иймд төсөл эхлэхийн өмнө Монгол Улсын MNS 5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага стандартын дагуу эко жорлонг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. Тус эко жорлон нь 5 тонн эзэлхүүнтэй ба хөрсний нэвчилт үүсгэхээс сэргийлэн суурийг бетондсон, ашиглахад хялбар байх үүднээс зориулалтын суултууртай, агааржуулагчтай, жорлонгийн их бие нь модон хийцтэй.

Зураг 3. Төслийн талбайд барьсан эко нүхэн жорлон



Эко жорлонгийн ариутгал халдваргүйжүүлэлтийг 0.1% жавелины уусмал ашиглан хийж, хорхой шавж, нян үржихээс сэргийлсэн.

Зураг 4. Ариутгал хийж буй байдал



## 5.5 Бохир соруулах зориулалтын машинаар соруулж аймгийн цэвэрлэх байгууламжид нийлүүлэх

2024.01.03-ны өдөр “Хэнтий-Ус” ХХК-тай бохир соруулах үйлчилгээний гэрээ байгуулсан ба бохир соруулах үед гэрээний дагуу зориулалтын тээврийн хэрэгслээр соруулж, зохих цэгт зайлуулан ажиллахаар төлөвлөж байна (Хавсралт 10). Талбайд дулааны улиралд талбайд 2-5 хүн, өвлийн улиралд 2 хүн байрлаж ажилладаг тул бохир соруулах хэрэгцээ шаардлага үүсээгүй.

## 6 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелүүлсэн байдал	Биелэлтийн хувь
6.1	Өмнөх жил тарьсан модны арчилгаа тордолгоо хийх /усалгаа, бордоо, хог ургамал түүх, нөхөн тарилт/	2023 онд Агч, Хайлаас гэсэн 2 төрлийн 2-3 настай 9370 ширхэг модны суулгацыг тариалангийн талбайг тойруулан салхинаас хамгаалах ойн зурвас хэлбэрээр тарьсан. 2024 оны 4-р сараас 10-р сарыг дуустал нормын дагуу усалгааг хийсэн.	100%
6.2	Өмнөх жил тарьсан модны арчилгаа тордолгоо хийж сумын ЗДТГ-т хүлээлгэн өгөх	Автозам дагуух ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, нөхөн тарилтыг 2023-2024 оны хооронд 100% хариуцан, Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2024 оны 10-р сарын 17-ны өдрийн А/280 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хүлээлгэн өгч, акт үйлдэн баталгаажуулсан.	100%
6.3	Тариалалтын чиглэлээр орон нутгийн иргэдэд сургалт явуулах, чихэр өвсний үрсэлгээг ургуулах, арчилгаа тордолгоо хийлгэх	2024.03.29-30-ны өдрүүдэд Чихэр өвс тариалахаар сонирхож буй иргэдэд сургалт явуулж, 100 иргэнтэй гэрээ байгуулан хамтарч ажилласан.	100%
6.4	Тасалгааны нөхцөл болон зуны хүлэмжинд үрсэлгээ хийх	100 иргэнд 10,000 ширхэг үрсэлгээ тараан өгсөн ба үүнээс 8,237 ширхэг үрсэлгээг хүлээн авсан. Тариалангийн талбайд байрлах 2 ширхэг зуны хүлэмжид 19,762 ширхэг үрсэлгээ үрслүүлсэн.	100%
6.5	Үрсэлгээг гадна талбайд шилжүүлэн суулгах, арчилгаа тордолгоо хийх	2023 онд үрсэлгээгээр тариалсан талбайн баруун талд 1.0 га талбайн хөрсийг боловсруулж иргэдээс авсан 8,237 ширхэг үрсэлгээ болон хүлэмжид тариалсан 19,762 ширхэг үрсэлгээг ил талбайд шилжүүлэн суулгаж, усалгаа арчилгааг тогтмол хийсэн.	100%

### 6.1 Өмнөх жил тарьсан модны арчилгаа тордолгоо хийх

Газрын тухай хууль, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Бүх нийтийн мод тарих өдрөөр өөрийн эзэмшил талбайд Агч /Amur maple/, Хайлаас /Ulmus sp/ гэсэн 2 төрлийн нийт 9370 ширхэг мод тарьсан. Тухайлбал; урд хашаалсан талбайд Агч Acer (maple) 1414 ширхэг, хойд хашаалсан талбайд Хайлаас (Ulmus sp.) 7956 ширхэг 2-3 настай суулгацыг тарьж усалгаа, арчилгаа хийж байна. Модны ургалт, өсөлт хөгжлийг дэмжих үүднээс гумины бордоо ашиглан усалгаа хийсэн.

Зураг 5. Модны усалгаа хийж буй байдал



Үүнээс гадна тариалангийн талбайн ойн зурвасын нөхөн тарилтад ашиглах Хайлаас /Ulmus sp./ модны 3 кг үр түүж, хүлэмжинд тариалсан. Ингэснээр тухайн бүс нутгийн цаг уур, хөрсөнд тохирсон модны үрээр үржүүлэг хийж, цаашдын нөхөн тариалалтад ашиглах боломж бүрдсэн. Үндсээ авсан тарьцыг бортгонд суулгаж, хүлэмжинд өвөлжүүлээд дараа жилийн нөхөн тарилтад ашиглана /Ургалт 100%/.

Зураг 6. Хүлэмжинд үрээр тарьсан хайлаасны ургалт



## 6.2 Өмнөх жил тарьсан модны арчилгаа тордолгоо хийж сумын ЗДТГ-т хүлээлгэн өгөх

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Чингис хотоос Бэрх тосгон чиглэлийн хатуу хучилттай авто замын 2 талаар хашаажуулж, мод тарих ажлыг төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс санаачилан 2022 оны 08-р сарын 17-ны өдөр Хэнтий аймгийн Хэрлэн сумын ЗДТГ-тай “Санамж бичиг” байгуулсан.

Зураг 7. Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах арга хэмжээ



Тус ажлын хүрээнд авто замын урд, хойд талд тус тус 5 км (нийт 10 км) торон хашаа татаж Хайлаас (*Ulmus sp.*) 200 ширхэг, Голт бор (*Lilac*) 1802 ширхэг суулгацыг тариалсан. Мөн усалгааны асуудлыг шийдвэрлэх үүднээс 5 тонн хэмжээтэй 14 ширхэг усны нөөцийн савыг замын хөвөөн дээр байршуулсан.

2023-2024 онуудад автозам дагуух ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа тордолгоо, нөхөн тарилтыг 100% хариуцан гүйцэтгэсэн. Усалгаа хийхдээ модны өсөлт, хөгжлийн дэмжих үүднээс гумины бордоо ашигласан. Нэгдсэн хогийн цэгээс салхиар их хэмжээний хог хийсэж модны нүхэнд орсноор модны ургалтыг хязгаарлаж байсан тул тухай бүр хог хаягдлын цэвэрлэгээг хийсэн.

Зураг 8. Усалгаа хийгдэж буй байдал








### 6.3 Тариалалтын чиглэлээр орон нутгийн иргэдэд сургалт явуулах, чихэр өвсний үрсэлгээг ургуулах, арчилгаа тордолгоо хийлгэх

2024.03.29-30-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хурлын танхим болон Хэнтий аймгийн Политехник коллежийн Урлагийн зааланд “Чихэр өвсний үрсэлгээ, усалгаа арчилгаа хийх” мэдээлэл хүргэх уулзалтыг зохион байгууллаа. Тус уулзалтанд дараах асуудлыг танилцуулав. Үүнд:

- Төслийн хүрээнд сум орон нутагт хийгдсэн ажил
- Чихэр өвсний үрсэлгээ, усалгаа арчилгааны талаар өмнөх жилийн туршлага, анхаарах асуудал

2024.03.29-04.02-ны өдрүүдэд 2024 онд хийгдэх “Нэг өрх – 100 үрсэлгээ” ажлын хүрээнд 100 иргэнтэй гэрээг байгуулсан.

Зураг 11. Танилцуулга, сургалт зохион байгуулсан байдал



*Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хурлын танхим*



*Хэнтий аймгийн Политехник коллежийн Урлагийн заал*

### 6.4 Тасалгааны нөхцөл болон зуны хүлэмжинд үрсэлгээ хийх


Чихэр өвсний үрсэлгээ ургуулах гэрээ байгуулсан иргэдэд 2024.04.10-ны дотор үрсэлгээг тарааж өгөхөөр төлөвлөж, хүлэмжинд үрсэлгээ хийх ажлыг зохион байгуулсан. 10,000 ширхэг үрсэлгээг суулган 100 иргэнд чихэр өвсний үрсэлгээг хүлээлгэн өгсөн. Чихэр өвсний үрсэлгээг ургуулж буй 20 иргэдээс нөхөн тарилт хийж өгөх хүсэлт ирүүлсний дагуу 410 ширхэг үрсэлгээг нөхөн тарьсан.

Зураг 12. Иргэдэд тараан өгөх үрсэлгээ бэлдэж, хүлээлгэн өгч буй байдал



Төслийн талбайд 6х20 м, 7х22 метрийн урттай 2 ширхэг зуны хүлэмжийг ашиглаж байгаа бөгөөд 2024 оны 04-р сарын сүүлээр хүлэмжинд үрсэлгээ тарих ажлыг эхлүүлсэн. Тайлант онд нийтдээ 46,000 ширхэг чихэр өвсний үр суулгасан хэдий ч 19,762 ш үр ургаж үрсэлсэн.

Зураг 13. Хүлэмжин дэх ажлын явц



### 6.5 Үрсэлгээг гадна талбайд шилжүүлэн суулгах, арчилгаа тордолгоо хийх

Чихэр өвсний үрсэлгээ тарьж ургуулахаар гэрээ байгуулсан 100 иргэнээс 8237 ширхэг үрсэлгээг хүлээн авсан ба үрсэлгээний ургалт нь ургах орчин, арчилгаа тордолгооноос

хамааран харилцан адилгүй байсан. Ургалтын байдал 82.3% буюу 2023 онтой харьцуулахад 2.6%-иар илүү байна.

Зураг 14. Үрсэлгээг тоолж, хүлээн авч буй байдал



Тайлант онд 100 иргэнээр тасалгааны нөхцөлд ургуулсан үрсэлгээ болон тариалангийн талбайд байрлах 2 ширхэг зуны хүлэмжинд ургуулсан үрсэлгээг гадна талбайд шилжүүлэн суулгах ажил 6-р сард хийгдсэн. Ингэхдээ 1.0 га талбайн хөрсийг хагалж, органик бордоо цацаж, хөрс боловсруулалтыг хийсэн ба үрсэлгээг мөрөөр тарих үүднээс хөрсийг хамарласан. Ил талбайд шилжүүлэн суулгах ажилд орон нутгийн 20 гаруй иргэн оролцсон ба нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдэд цалин хөлсийг тухай бүр олгосон.

Зураг 15. Үрсэлгээг ил талбайд шилжүүлэн суулгах ажлын явц



Зураг 16. 2024 онд тарьсан чихэр өвсний үрсэлгээний ургалтын байдал



## 7 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Эзэмшлийн талбай нь өмнө тариалангийн зориулалтаар ашиглаж байгаад атар газар болгосон учир түүх соёлын дурсгалт олдвор байхгүй болно.

## 8 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелүүлсэн байдал	Биелэлтийн хувь
8.1	Ажиллагсдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах (2 ээлжийн хувцас, малгай, гутал, шил, бээлий)	Талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр ханган ажилласан.	100%

Талбайд ажиллаж буй ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хамгаалах үүднээс зориулалтын хувцас хэрэгслээр хангаж ажилласан. Тухайлбал; гадаа талбайд олон цагаар ажилладаг ажилчдад ялаа шумуул, нарнаас хамгаалах торон малгай, нүдний шил, бээлий, гутал, борооны цув, ажлын хувцас, хантааз, усны гутал зэргийг олгосон.

Зураг 17. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангасан байдал



## 9 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелүүлсэн байдал	Биелэлтийн хувь
9.1	Сум орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөрийг тогтмол хугацаанд төлөх	“Өндөрхаан тохижилтын газар” ОНТҮГ-тай 2024 оны 09-р сарын 09-ны өдөр Хог хаягдлын тухай аж ахуйн гэрээ байгуулан үйл ажиллагаанаас гарч буй энгийн хог хаягдлыг хогийн цэг рүү зайлуулж, 204,000 төгрөгийг хураамжийг төлсөн (Хавсралт 12).	100%
9.2	Хог хаягдлын ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байрлуулах	Эко нүхэн жорлонгийн орчимд үйл ажиллагаанаас гарах энгийн хог хаягдлыг түр хуримтлуулах, ангилан ялгах зориулалт бүхий төмөр, таглаатай поошиг байрлуулсан. Мөн ангилан ялгалтыг эх үүсвэр дээр нь хийх үүднээс тэмдэгжүүлсэн.	100%
9.3	Салхиар зөөгдөн ирсэн хог хаягдлыг тогтмол хугацаанд цэвэрлэж байх	Талбайн эмх цэгцтэй байдал, бохирдол үүсэхээс сэргийлж хогийн цэгээс хийсч ирсэн хог хаягдлыг сард 1 удаа түүж цэвэрлэн хогийн цэг рүү тээвэрлэн хаясан.	100%

### 9.1 Сум орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөрийг тогтмол хугацаанд төлөх

Хэнтий аймгийн “Өндөрхаан тохижилтын газар” ОНТҮГ-тай №24 дугаартай Хог хаягдлын тухай аж ахуйн гэрээг 2024 оны 09-р сарын 09-ны өдөр байгуулсан (Хавсралт 3). Үйл ажиллагаанаас үүссэн ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт өөрийн тээврийн хэрэгслээр буулгаж зохих төлбөрийг төвлөрүүлдэг. 2024 оны 09-р сараас 2025 оны 09-р сар хүртэлх хог хаягдлын хураамжинд 204,000 төгрөгийг орон нутгийн татварын хэлтэст төлсөн (Хавсралт 10).

### 9.2 Хог хаягдлын ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байрлуулах

Талбайд байрлах манаач нарын ахуйн хэрэглээнээс энгийн хог хаягдал үүсэх ба хоногт дунджаар 0.3 кг хог үүснэ гэж үзээд эко бие засах газрын орчимд хог хуримтлуулах төмөр поошиг байрлуулсан. Тус поошиг нь ангилан ялгах зориулалттай 2 ширхэг, хог хаягдал салхинд хийсэхээс сэргийлсэн төмөр тагтай, тэмдэг тэмдэглэгээтэй болно.

Зураг 18. Хог хаягдал ангилан хадгалах төмөр поошиг байршуулсан байдал



### 9.3 Салхиар зөөгдөн ирсэн хог хаягдлыг тогтмол хугацаанд цэвэрлэж байх

Талбайн баруун, баруун хойд талд байрлах хогийн цэгээс их хэмжээний хог хаягдал салхиар хийсч ирдэг тул сар бүр хог хаягдлын цэвэрлэгээг хийж цуглуулсан хог хаягдлыг хогийн цэг рүү тээвэрлэж зайлуулдаг. Тайлант онд 6 удаагийн цэвэрлэгээ хийж 10 тонн хог хаягдал ачсан. Хогийн цэгээс хийсч ирж буй хог нь тариалангийн талбай болон модны нүхэнд хуримтлагдаж модны ургалтын явцыг сааруулж (агаар, байгалийн гэрэл дутагдах) байна.

Зураг 19. Хог хаягдлын цэвэрлэгээ хийж буй байдал



Талбайн баруун, хойд хэсэгт үхсэн малын сэг зэм хаясан байсныг цэвэрлэж зайлуулсан.

Зураг 20. Талбайн эргэн тойрны нөхцөл байдал



## 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелүүлсэн байдал	Биелэлтийн хувь
10.1	Аэрозол: Нийт тоос 8 цэгт	Хэнтий аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн лаборант агаарын 8 цэгээс сорьц цуглуулж, хэмжилт хийсэн.	100%
10.2	Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ /NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> / 8 цэгт		100%
10.3	Гадаад орчны дуу шуугианы хэмжилт 8 цэгт	Дуу шуугианы хэмжилтийн багажаар 8 цэгт хэмжилт хийсэн ба стандартаас давсан үзүүлэлт илрээгүй.	100%
10.4	Усны ерөнхий үзүүлэлт 2 дээж	Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид усны ерөнхий үзүүлэлтийн 2 дээж шинжлүүлсэн.	100%
10.5	Усны хүнд металын шинжилгээ 2 дээж		100%
10.6	Усны бактерлогийн шинжилгээ 2 дээж	Хэнтий аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лабораторид усны эрүүл ахуйн 2 дээж шинжлүүлсэн.	100%
10.7	Хөрсний хими-физикийн ерөнхий Үзүүлэлт 4 цэгт	Нарт ШУҮН Консалтинг ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид хөрсний агрохимийн 20 дээж, хүнд металл 12, эрүүл ахуйн 1 дээжийг шинжлүүлсэн.	100%
10.8	Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт 2 цэгт		100%
10.9	Хөрсний хүнд металлын үзүүлэлт 4 цэгт		100%
10.10	Ургамлын мониторинг 1 удаа	Тариалангийн талбайд ургамлын мониторинг судалгааг хийж 14 цэгт геоботаникийн бичиглэл хийсэн.	100%

Хүснэгт 2. ОХШХ-ийн хүрээнд дээж авч лабораторид шинжлүүлсэн байдал

№	Шинжлүүлсэн үзүүлэлт	Тоо хэмжээ	Шинжилгээ хийсэн лаборатори
1	Тоос, азотын давхар исэл, хүхрийн давхар исэл	8	Хэнтий аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн лаборатори
2	Усны ерөнхий үзүүлэлт	2	Газарзүй-Геоэкологийн хүрээлэн усны шинжилгээний лаборатори
3	Усны эрүүл ахуйн үзүүлэлт	2	Хэнтий аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лаборатори
4	Хөрсний агрохими	20	Нарт ШУҮН Консалтинг ХХК-ийн итгэмжлэгдсэн лаборатори
5	Хөрсний хүнд металл	13	
	Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт	1	

### Агаарын чанар

Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн лабораторид агаарын сорьцон дах тоос, азотын давхар исэл, хүхрийн давхар исэл гэсэн 3 үзүүлэлтийг тодорхойлуулсан ба тус төвийн цаг уурын инженер, лаборантууд агаарын сорьцын хэмжилтийг талбай дээр хийсэн.

Зураг 21. Агаарын сорьц авч буй байдал



Эзэмшлийн талбайн кемп, чихэр өвсний тариалангийн талбай, урд талбайн гол хэсэг, хуучин хогийн цэг, тэжээлийн олон наст тариалсан талбай, ногоон тэжээл тариалсан талбай, нарийн тэжээл тариалсан талбай, хогийн цэг орчим гэсэн нийт 8 цэгт Dust Trak багажаар хэмжилт хийж үр дүнг MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандарттай харьцуулахад стандартаас давсан үзүүлэлт илрээгүй (Хавсралт 7).

Хүснэгт 3. Агаарын сорьцын шинжилгээний дүн

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж		Хүлцэх агууламж	Сорьцын дугаар							
			100	101	102	103	104	105	106	107
MNS 17.2.5. 12:88	Хүхэрлэг хий SO <sub>2</sub> , мг/м <sup>3</sup>	0.45	0.014	0.018	0.012	0.008	0.010	0.011	0.010	0.011
MNS 17.2.5. 12:88	Азотын давхар исэл NO <sub>2</sub> , мг/м <sup>3</sup>	0.2	0.032	0.006	0.013	0.012	0.029	0.000	0.007	0.012
CA3 A03	Тоос – нийт, мг/м <sup>3</sup>	0.15	0.013	0.020	0.037	0.004	0.002	0.012	0.007	0.013

### Дуу шуугианы хэмжилт

Талбай дах дуу шуугианы хэмжилтийг DT-8820 Environment meter дуу шуугианы түвшин хэмжигч багаж ашиглан 8 цэгт хэмжилт хийж Монгол Улсын MNS 4585:2016 стандарттай харьцуулсан. Хэмжилтийн үр дүнгээс үзэхэд байгалийн салхи ихтэй учир зарим хэмжилтүүд стандартаас өндөр гарсан. Түүнээс суурин дуу чимээ үүсгэх эх үүсвэр талбайн ойролцоо байхгүй болно.



Зураг 22. Дуу чимээний хэмжилт хийж буй байдал



Хүснэгт 4. Дуу чимээний хэмжилтийн дүн

№	Байршил	Температур, С°	Чийг	Дуу шуугиан дба	
				Хамгийн их	Хамгийн бага
1	Хогийн цэг орчим	28.2	27.6	63.2	56.2
2	Хуучин хогийн цэг	26.2	27.6	71.9	58.6
3	Түр кемп	23.9	30.2	63.3	44.7
4	Хүлэмж орчим	29.4	22.7	54.5	45.2
5	Урд хашааны төв хэсэгт	28.7	22.9	73.5	50.8
6	Тэжээлийн олон наст тариалсан	30.0	25.3	76.8	61.5
7	Ногоон тэжээл тариалсан талбай	29.5	24.1	79.0	67.0
8	Ногоон тэжээл тариалсан талбай	29.7	25.4	70.2	55.6

#### Усны шинжилгээ

2024 оны 09-р сарын 11-ний өдөр Худаг №1, 2-оос усны дээж авч эрүүл ахуйн үзүүлэлтийг Хэнтий аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид шинжлүүлэхэд Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартад нийцэж байна (Хавсралт 5).

Хүснэгт 5. Усны нянгийн шинжилгээний дүн

Дээжний дугаар	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Шаардлага	Шинжилгээний дүн
589 (худаг 1)	Ббет	1 мл-т ббет 100-с ихгүй	1 мл-т ББЕТ 7
	Salmonella sp	25 мл-д salmonella sp илрэх ёсгүй	25 мл-д salmonella sp илрээгүй
	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян	100 мл-д халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян илрэх ёсгүй	100 мл-д халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян илрээгүй
590 (худаг 2)	Ббет	1 мл-т ббет 100-с ихгүй	1 мл-т ББЕТ 10
	Salmonella sp	25 мл-д salmonella sp илрэх ёсгүй	25 мл-д salmonella sp илрээгүй
	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян	100 мл-д халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян илрэх ёсгүй	100 мл-д халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян илрээгүй

2024 оны 09-р сарын 11 болон 10 сарын 18-ны өдөр худаг №1, 2-оос дээж авч усны ерөнхий үзүүлэлтийг Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид шинжлүүлэхэд Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартад нийцэж байна (Хавсралт 6).

Хүснэгт 6. Усны ерөнхий үзүүлэлтийн шинжилгээний дүн

Д.д	Элемент	Нэгж	9 сарын 11		10 сарын 18		MNS 0900:2018
			Худаг 1	Худаг 2	Худаг 1	Худаг 2	
<b>Анион</b>							
1	Хлорид (Cl)	мг/л	9.9	8.2	12.1	11.0	350
2	Сульфат (SO <sub>4</sub> <sup>2-</sup> )	мг/л	35.0	40.0	7.0	8.0	500
3	Нитрат (NO <sub>3</sub> )	мг/л	10.0	10.0	16.0	18.0	50
4	Нитрит (NO <sub>2</sub> )	мг/л	0	0	0	0	1
5	Карбонат (CO <sub>3</sub> <sup>2-</sup> )	мг/л	6.0	0	0	0	-
6	Гидрокарбонат (HCO <sub>3</sub> <sup>2-</sup> )	мг/л	280.6	298.9	323.3	317.2	-
<b>Катион</b>							
7	Кали (K <sup>+</sup> )	мг/л	34.1	36.2	40.3	35.4	200
8	Натри (Na <sup>+</sup> )	мг/л					
9	Кальци (Ca <sup>2+</sup> )	мг/л	55.9	57.1	53.5	55.7	100
10	Магни (Mg <sup>2+</sup> )	мг/л	20.7	20.7	19.7	20.1	30
11	Аммони (NH <sub>4</sub> <sup>+</sup> )	мг/л	0	0	0	0	1.5
12	Fe <sup>+++</sup>	мг/л	0	0	0	0	0.3
<b>Физик шинж чанарын үзүүлэлтүүд</b>							
13	pH	-	7.74	7.58	7.62	7.50	6.5-8.5
14	Ерөнхий хатуулаг	Мг-экв/л	4.49	4.55	4.29	4.43	7
15	Цахилгаан дамжуулах чадвар	Us/m	546	564	570	590	-
16	Хуурай үлдэгдэл, TDS	Ppm	300	310	285	295	-

Зураг 23. Худгийн уснаас дээж авч буй байдал

Худаг 1



Худаг 2



### Хөрсний шинжилгээ


Хөрсний дээжийг тариалалт хийсэн болон тариалалт хийгдээгүй талбай, эко жорлон, хогийн цэг, модны нүх гэх мэт байршлуудаас авч шинжилгээнд өгсөн.

Хүснэгт 7. Хөрсний дээж авсан цэгийн байршил, шинжлүүлсэн үзүүлэлт

№	Дээжний дугаар	Байршил	N	E	h	Шинжлүүлсэн үзүүлэлт
1	Дээж -1	Хойд талбайн урд хэсэг	47.37119	110.69333	1028 м	Агрохими, Хүнд металл
2	Дээж -2	Урд талбайн төв хэсэг	47.36182	110.70860	1031 м	Агрохими, Хүнд металл
3	Дээж -3	Хойд талбайн зүүн хэсэг	47.39673	110.69723	1030 м	Агрохими, Хүнд металл
4	Дээж -4	Хойд талбайн баруун хойд хэсэг	47.37529	110.69852	1030 м	Агрохими, Хүнд металл
5	Дээж -5	Хойд талбайн баруун урд хэсэг	47.37441	110.68586	1034 м	Агрохими, хүнд металл
6	Дээж -6	Урд талбайн зүүн урд хэсэг	47.35871	110.72236	1028 м	Агрохими, хүнд металл
7	Дээж -7	Урд талбайн хойд хэсэг	47. 36979	110. 70100	1031 м	Агрохими, хүнд металл
8	Дээж -8	Хойд талбайн урд хэсэг	47. 37529	110. 69852	1030 м	Агрохими, хүнд металл
9	Дээж -9	Хойд талбайн баруун урд хэсэг	47.37365	110.68665	1034 м	Агрохими, хүнд металл

10	Дээж -10	Хойд талбайн зүүн хойд хэсэг	47.40445	110.68519	1044 м	Агрохими, хүнд металл
11	Дээж -11	Хойд талбайн зүүн урд хэсэг	47.38759	110.70423	1030 м	Агрохими, хүнд металл
12	Дээж -12	Хойд талбайн төв хэсэг	47.38041	110.69386	1030 м	Агрохими, хүнд металл
13	Бох-1	Эко нүхэн жорлон орчим	47.35434	110.71428	1026 м	Эрүүл ахуй
14	Бох-2	Хог хаягдал түр хадгалах цэгийн орчим	47.35439	110.71438	1026 м	Хүнд металл

Зураг 24. Хөрсний дээж авсан цэгүүд



Дээж №1: N47.37119, E110.69333, 1028 м

Дээж №2: N47.36182, E110.70860, 1031 м

Бохирдол №2: Хог хаягдал түр хадгалах цэгийн орчим  
N47.35439, E110.71438, 1026 м

Дээж №3:  
N47.39673, E110.69723, 1030 м


Дээж №4:  
N47.37529, E110.69852, 1030 м



Дээж №5:  
N47.37441, E110.68586, 1034 м



Дээж №6: N47.35871, E110.72236, 1028 м



Дээж №7: N47.36979, E110.70100, 1031 м




Дээж №8:  
N47.37529, E110.69852, 1030 м




Дээж №9:  
N47.37365, E110.68665, 1035 м



Дээж №10:  
N47.40445, E110.68519, 1044 м



Дээж №11:  
N47.38759, E110.70423, 1030 м





Дээж №12:  
N47.38041, E110.69386, 1030 м



Бохирдол №1: Эко нүхэн жорлон орчим  
N47.35434, E110.71428, 1026 м

Хүснэгт 8. Хөрсний дээжний агрохимийн шинжилгээний дүн

№	Дээж авсан үе давхарга	Ph	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	NO <sub>3</sub> мг/л	Солилцох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca <sup>+2</sup>	Mg <sup>+2</sup>	P <sub>2</sub> O <sub>5</sub> мг/л	K <sub>2</sub> O
1	A	6.59	0.004	0.011	2.35	0	0.02	12	13	0.3	6
	B	6.47	0.005	0.013	1.19	0	0.03	15	10	1.7	10
2	A	6.97	0.007	0.017	2.24	0	0.05	13	10	1.6	8
	B	7.62	0.024	0.059	2.11	1.14	0.22	10	10	2.6	10
3	A	6.53	0.006	0.014	2.05	0	0.04	15	10	1.3	6
4	A	6.6	0.004	0.01	1.92	0	0.02	12	8	0.6	4
	B	6.54	0.004	0.011	0.8	0	0.02	9	6	1.3	5
5	A	6.48	0.004	0.009	1.67	0	0.02	16	9	1	4
	B	6.51	0.004	0.011	0.71	0	0.02	13	10	1.1	6
6	A	7.17	0.004	0.011	2.08	0	0.02	12	11	1.8	7
	B	7.31	0.006	0.014	1.13	0	0.04	10	8	1.8	10
7	A	6.53	0.005	0.012	4.11	0	0.03	22	14	0.8	6
	B	6.55	0.005	0.012	2.37	0	0.03	18	8	1.6	4
8	A	6.95	0.009	0.022	2.37	0	0.07	14	12	1.7	9
	B	6.48	0.004	0.009	2.07	0	0.02	13	10	1.1	6
9	A	6.95	0.006	0.014	1.52	0	0.04	11	8	2.2	3
	B	7.23	0.014	0.035	0.43	1.44	0.12	7	10	1.4	2
10	A	6.51	0.003	0.008	2.16	0	0.01	14	12	0.2	4
11	A	6.43	0.004	0.01	2.21	0	0.02	13	10	0.7	4
12	A	6.7	0.004	0.011	1.78	0	0.02	14	7	1.1	2

Хөрсний ялзмагийн агууламж 0.43-4.11% буюу үржил шим харилцан адилгүй маш багаас дунд зэрэг, давсжилтгүй, урвалын орчин 6.43-7.62 буюу бага хүчиллэгээс бага шүлтлэгийн хооронд /саармаг маягийн/ хэлбэлзэж байна. Хөдөлгөөнт шим тэжээлийн бодисын хувьд хөдөлгөөнт фосфор 100 гр хөрсөнд 0.2-2.6 мг-экв байгаа нь үржил шимийн агууламж бага зэрэг хангамжтай байна. Харин солилцох калийн хувьд 100 гр хөрсөнд 2-10.0 мг-экв байгаа нь бага хангамжтай хөрс байна (Хавсралт 8).

Хүснэгт 9. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн

Дээжний дугаар	Нянгийн тоо MNS:ISO 6341: 2012	Гэдэсний савханцрын титр (E coli) MNS:ISO 5367:2004		Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	
		Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
Бох-1	5.8*10 <sup>5</sup>	0.01	1	>0.1	1

Хөрсний эрүүл ахуйн микробиологийн шинжилгээг MNS6341:2012, MNS5367:2004 стандартуудыг баримтлан итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсний бактерийн нийт тоо 5.8\*10<sup>5</sup> мл/эс байгаа нь I зэрэг, өвчин үүсгэгч гэдэсний бүлгийн савханцар Escherichia coli, Clostridium perfringens илрээгүй буюу биологийн бохиролгүй хөрс болохыг илтгэж байна (Хавсралт 9).

Хүснэгт 10. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

Дээжний дугаар	Агууламж мг/кг					
	Никель Ni	Кадми Cd	Хар тугалга Pb	Цайр Zn	Хром Cr	Зэс Cu
Дээж 1	13.9	0.0	10.75	30	76.9	29.25
Дээж 2	20	0.0	27.5	12.5	23.1	9.4
Дээж 3	11.1	0.0	20	62.5	46.2	23.1
Дээж 4	3.55	0.0	7.5	39.6	40.8	12.65
Дээж 5	5.55	0.0	10	40.9	58.9	12.9
Дээж 6	19.4	0.0	35	44	54.6	11.85
Дээж 7	15.5	0.0	25	72.1	60.5	28.5
Дээж 8	12.3	0.0	12.9	30	57.7	58.6
Дээж 9	7.15	0.0	2.5	43.6	57.8	14.5
Дээж 10	2	0.0	5	37.6	56.9	13.2
Дээж 11	9.9	0.0	15	45.5	52.3	21.3
Дээж 12	13.9	0.0	17.5	55	83.2	23.7
Бох-2	14.5	0.0	25	17.85	60	11.55
MNS 5850:2019 Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	150	3	100	300	150	100

Хөрс бохирдуулагч хүнд металлуудаас кадми илрээгүй, никель 2-20 мг/кг, хар тугалга 2.5-27.5 мг/кг, цайр 12.5-72.1 мг/кг, хром 23.1-83.2 мг/кг, зэс 9.4-58.6 мг/кг буюу Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019 стандартын шаардлагад нийцэж байна (Хавсралт 9).

**Ургамлын мониторинг**

Эзэмшлийн талбайн дотор болон гадна нийт 14 цэгт ургамлын геоботаникийн бичиглэл хийсэн. Ургамлын геоботаникийн судалгаагаар *Агь Artemisia frigida*, *Монгол шарилж Artemisia mongolica*, *Шүлхий шарилж Artemisia pectinata*, *Сортой лууль Chenopodium Aristatum*, *Дэрвээн хазаар өвс Cleistogenes squarrosa*, *Согсоолж Heteropappus.sp*, *Будан барбад Leptopyrum fumarioides*, *Бөөнөг хамхуул Corispermum declinatum*, *Дээврийн банга Crepis tectorum*, *Жамба цэцэг Malva sylvestris*, *Тогторгоно Kochia.sp*, *Гичгэнэ Potentilla.sp*, *Улалж carex.sp*, *Багваахай Taraxacum.sp*, *Ээрэм шарилж Artemisia macrocephala*, *Чөдөр гиш Vicia cracca*, *Хамхуул Corispermum.sp*, *Софийн бор бум Descurainia sophia*, *Өмхий шарилж Artemisia adamsii*, *Хуаг Agropyron.sp*, *Хогийн цангуу Lepidium.sp*, *Анхилуун лууль Chenopodium botrys*, *Хөдөөний шаралзгана Sonchus arvensis*, *Ишгэн шарилж Artemisia dracunculoides*, *Олслиг халгай Urtica cannabina*, *Нарийн ишт юнги Youngia tenuicaulis*, *Мөлхөө шээрэнгэ Silene repens*, *Саман ерхөө Agropyron cristatum*, *Алтан гагнуур Rhodiola rosea*, *Одой далан түрүү Stellera chamaejasme*,

Эгэл гаймуу *Capsella bursa-pastoris*, Шувуун тарна *Polygonum aviculare* гэх мэт ургамлуудыг бүртгэсэн.

Тус талбайг өмнө нь тариалангийн зориулалтаар ашиглаж байгаад атаршуулсан тул хөрсний үржил шим багатай, ургамлын бүлгэмдлийн хувьд үетэн-шарилж-лууль, ургамлын амьдралын хэлбэрийн хувьд хагас сөөгөнцөр, нэг наст болон олон наст ургамал зонхилон тархсан байна. Өмнөх жилүүдтэй харьцуулахад ургамлын арви, бүрхэцийн хэмжээ нэмэгдсэн ба талбайг бүхэлд нь хашаажуулж мал амьтан орох, олон салаа зам үүсгэх, газрын гадаргыг доройтуулж талхалхаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой.

